

Сургалтын төлбөрийг төлөх болон буцаан олгох тухай журам

1. Төлбөр төлөх журам

- Сургалтын төлбөрийг заасан хугацаанд банкны данс руу шилжүүлнэ.
- Хэрэв заасан хугацаанд төлбөр төлөөгүй, эсвэл дансанд төлбөр орж ирээгүй тохиолдолд оюутныг бүртгэлээс хасна.
- Сургалтын төлбөрийг хойшлуулахгүй.

2. Төлбөр буцаан олгох журам

Нэгэнт хүлээн авсан сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

Зөвхөн доор заасан нөхцлийн аль нэгэнд хамаарах хүмүүс өөрсдөө хүсэлт гаргасан тохиолдолд, заасан журмын дагуу буцаан олгоно.

(1) Виз олгоогодоогүй хүмүүс: буцаан олголтын журмын дагуу манай сургуульд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн байх.

Үүнд: сургуульд элсэх бичиг; төлбөр буцаан олгох бичиг; паспортын хуулбар

(2) Элсэлтийн ёслолын өмнө сургуульд элсэн суралцахаас татгалзсан хүмүүс: Тухайн оюутан Япон улсын хилээр орж ирээгүй байх ёстой ба дараах зүйлсийг бүрдүүлсэн байх.

Үүнд: Certificate of eligibility- японд оршин суух зөвшөөрлийн бичиг; эсвэл визаг хүчингүй болгож тамга даруулан паспортны хуулбарыг хавсаргах; элсэн суралцах гэрчилгээ; элсэн суралцахаас татгалзсан шалтгаан бичсэн өргөдөл; төлбөр буцаан олгох бичиг.

(3) 2-р улирал эхлэхээс өмнө их дээд сургуульд элсэн суралцах хүмүүс: 2-р улирлын хичээлд суугаагүй байх ёстой бөгөөд 2-р улирлын төлбөрийг буцаан олгоно.

Бүрдүүлэх бичиг баримт: оюутны үнэмлэх; төлбөр буцаан олгох бичиг; элсэн суралцах сургуулийн элсэлтийн бичиг.